



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар №/469

Арвайхээр сум

**Тендер хүчингүй болгох, гэрээ
шууд байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 83 дугаар дүгнэлтийн дагуу ӨВАОНӨГ/202306064 Аймгийн Хөгжимт драмын театрын дээврийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул хүчингүй болгосугай.

2.Тус тендерийг 3-аас доошгүй аж ахуйн нэгжид үнийн санал хүргүүлж гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0920

D:My Doc. Zahiramj. Zasag darga